

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**МАНХАН СПОРТ ЦОГЦОЛБОРЫН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН  
ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/129/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2021 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Мөнхтулга

Утас: 70432545

цахим хаяг: munkhtulga.d@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**Товчилсон үгийн жагсаалт**

<i>АДБООУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББООУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>ЗДТГ</i>	<i>Засаг даргын дамгын газар</i>
<i>ОНХС</i>	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	4
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	5
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	<b>Error! Bookmark not defined.</b>
3. Аудитын тайлан.....	8
3.1. Ерөнхий зүйл.....	8
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	8
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .....	9
3.4. Материаллаг байдал .....	9
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	9
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	10
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	11
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	11
3.9. Аудитын илрүүлэлт.....	11
Залруулсан алдаа.....	12
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ..	<b>Error! Bookmark not defined.</b>
Аудитын зөвлөмж.....	12
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	12
4. Менежментийн захидал.....	12
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	13

## 1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
04000 Цэндбегэвэс бөг, Нгаргалент сум, Ховд  
Утас: 076-70433061, Факс: 076-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

МАНХАН СПОРТ ЦОГЦОЛБОРЫН  
ДАРГА А.ДАШНЯМ ТАНАА

2021.09.05 № 2/26  
таний \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Манхан спорт цогцолборын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Манхан спорт цогцолборын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Манхан спорт цогцолборын 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### Үүрэг хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *А.БОЛДБААТАР*

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН****2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>14,753,365.18</u></b>	<b><u>12,983,500.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	557,565.18	527,800.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	557,565.18	-
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	527,800.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	14,195,800.00	12,455,700.00
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	28,000.00	-
35130	Эм боох материал	28,000.00	-
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	14,167,800.00	12,455,700.00
35410	Бичиг хэргийн материал	65,000.00	150,000.00
35420	Аж ахуйн материал	4,934,400.00	3,762,800.00
35470	Бусад хангамжийн материал	9,168,400.00	8,542,900.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,371,312,049.24</u></b>	<b><u>2,350,592,715.85</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,371,312,049.24	2,350,592,715.85
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,371,312,049.24	2,350,592,715.85
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,458,000,000.00	2,485,724,550.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(122,900,000.36)	(163,866,667.04)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	21,634,600.00	21,634,600.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(7,007,350.32)	(11,567,967.00)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	19,786,000.00	19,786,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,701,200.08)	(5,792,800.08)
39214	Бусад үндсэн хөрөнгө	5,500,000.00	5,500,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(825,000.03)
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,386,065,414.42</u></b>	<b><u>2,363,576,215.85</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>531,253.00</u></b>	<b><u>677,395.35</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	531,253.00	677,395.35
<b>413</b>	<b>Өглөг</b>	531,253.00	677,395.35
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	531,253.00	677,395.35
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,385,534,161.42</u></b>	<b><u>2,362,898,820.50</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,385,534,161.42	2,362,898,820.50
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	2,385,534,161.42	2,362,898,820.50
51210	Өмнөх үеийн үр дүн	2,385,534,161.42	2,385,534,161.42
51220	Тайлант үеийн үр дүн	-	(22,635,340.92)
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>2,386,065,414.42</u></b>	<b><u>2,363,576,215.85</u></b>

**2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b><u>122,267,339.00</u></b>	<b><u>163,763,550.00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b><u>14,641,139.00</u></b>	<b><u>32,724,550.00</u></b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	14,641,139.00	32,724,550.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	14,641,139.00	32,724,550.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	5,000,000.00

1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,641,139.00	27,724,550.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>107,626,200.00</b>	<b>131,039,000.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	107,626,200.00	131,039,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	107,626,200.00	131,039,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>156,780,626.74</b>	<b>186,398,890.92</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>156,780,626.74</b>	<b>186,398,890.92</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	156,780,626.74	186,398,890.92
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	57,975,360.94	63,961,340.00
210101	Үндсэн цалин	57,722,133.00	63,164,187.00
210102	Нэмэгдэл	248,874.00	797,153.00
210105	Гэрээт ажлын хөлс	4,353.94	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	7,396,775.92	7,995,167.53
210201	Тэтгэврийн даатгал	5,036,335.64	5,436,713.93
210202	Тэтгэмжийн даатгал	592,510.07	639,613.40
210203	ҮОМШӨ-ний даатгал	471,448.05	511,690.70
210204	Ажилгүйдлийн даатгал	117,862.02	127,922.70
210205	Эрүүл мэндийн даатгал	1,178,620.14	1,279,226.80
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	36,520,404.60	61,419,579.70
210301	Гэрэл, цахилгаан	2,012,904.60	2,388,579.70
210302	Түлш, халаалт	31,476,500.00	56,546,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,031,000.00	2,485,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	5,662,488.00	2,503,700.00
210401	Бичиг хэрэг	560,300.00	325,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,157,590.00	600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэгийн төлбөр	504,500.00	75,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	60,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,174,098.00	1,433,700.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	206,000.00	70,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	-	632,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	24,500.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	607,800.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	520,000.00	-
210702	Дотоод албан томилолт	520,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	89,900.00	537,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	447,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	89,900.00	90,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	48,615,697.28	49,349,803.69
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,292,130.40	905,920.30
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	46,323,566.88	48,443,883.39
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>(34,513,287.74)</b>	<b>(22,635,340.92)</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>(34,513,287.74)</b>	<b>(22,635,340.92)</b>

**2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		

<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>112,626,200.00</b>	<b>136,039,000.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>5,000,000.00</b>	<b>5,000,000.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,000,000.00	5,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	5,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>107,626,200.00</b>	<b>131,039,000.00</b>
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	107,626,200.00	131,039,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	107,626,200.00	131,039,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>112,926,486.00</b>	<b>136,039,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>112,926,486.00</b>	<b>136,039,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>112,926,486.00</b>	<b>135,511,200.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	58,243,602.00	62,777,800.00
210101	Үндсэн цалин	47,435,387.00	57,001,267.00
210102	Нэмэгдэл	-	5,776,533.00
210105	Гэрээт ажлын хөлс	10,808,215.00	-
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	7,243,000.00	8,475,000.00
210201	Тэтгэврийн даатгал	4,925,200.00	5,963,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	579,400.00	627,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	463,600.00	502,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	115,900.00	125,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,158,900.00	1,255,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	38,801,200.00	62,732,200.00
210301	Гэрэл, цахилгаан	4,014,700.00	3,300,000.00
210302	Түлш, халаалт	31,476,500.00	56,546,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,310,000.00	2,886,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,529,084.00	1,084,200.00
210401	Бичиг хэрэг	436,500.00	230,000.00
210402	Тээвэр, шатахуун	777,150.00	600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	533,600.00	75,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	281,350.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	500,484.00	179,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	500,000.00	120,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	500,000.00	120,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	520,000.00	-
210702	Дотоод албан томилолт	520,000.00	-
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	89,900.00	322,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	232,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	89,900.00	90,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	4,999,700.00	-
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,999,700.00	-
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>527,800.00</b>
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	-	527,800.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	527,800.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>(300,286.00)</b>	<b>-</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>(300,286.00)</b>	<b>-</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	300,286.00	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

**2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**  
төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,385,534,161.42	2,385,534,161.42
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>2,385,534,161.42</b>	2,385,534,161.42
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт		-

C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз		-
C07	Тайлант үеийн үр дүн		-
C08	<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,385,534,161.42</b>	2,385,534,161.42
D01	<b>2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	<b>2,385,534,161.42</b>	2,385,534,161.42
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт		-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2,385,534,161.42</b>	2,385,534,161.42
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт		-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		-
D08	Тайлант үеийн үр дүн	(22,635,340.92)	(22,635,340.92)
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2,362,898,820.50</b>	2,362,898,820.50

## 2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	136039000.00	135,511,200.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	136039000.00	135,511,200.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	136039000.00	135,511,200.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	60317000.00	62,777,800.00
210101	Үндсэн цалин	58327000.00	57,001,267.00
210102	Нэмэгдэл	1990000.00	5,776,533.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	10935800.00	8,475,000.00
210201	Тэтгэврийн даатгал	8559300.00	5,963,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	594100.00	627,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	475300.00	502,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	118800.00	125,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1188300.00	1,255,600.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	62736200.00	62,732,200.00
210301	Гэрэл, цахилгаан	3300000.00	3,300,000.00
210302	Түлш, халаалт	56550000.00	56,546,000.00
210303	Цэвэр, бохир ус	2886200.00	2,886,200.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	1190000.00	1,084,200.00
210401	Бичиг хэрэг	230000.00	230,000.00
210402	Тээвэр, шатахуун	600000.00	600,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	160,000.00	75,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	200,000.00	179,200.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	150,000.00	120,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	150,000.00	120,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	320,000.00	-
210702	Дотоод албан томилолт	320,000.00	

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	390,000.00	322,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	300,000.00	232,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	90,000.00	90,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	136,039,000.00	135,511,200.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	131,039,000.00	130,511,200.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	131,039,000.00	130,511,200.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	5,000,000.00	5,000,000.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	5,000,000.00
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	9	9
620001	Удирдах ажилтан	1	1
620002	Гүйцэтгэх ажилтан	4	4
620003	Үйлчлэх ажилтан	4	4

### 3. АУДИТЫН ТАЙЛАН

#### 3.1. Ерөнхий зүйл

Манхан спорт цогцолборын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга А.Дашням танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч анхан шатны баримт бүрдүүлэлт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 04-нөөс 2021 оны 02 дугаар сарын 05-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Мөнхтулга хариуцаж хэрэгжүүлэв.

#### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Манхан спорт цогцолборын үйл ажиллагааны эрхэм зорилго нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх, иргэд хүүхэд залуучуудын бие бялдар, чийрэгжилтийг дээшлүүлэх, нийгмийн эрүүл мэндийг дэмжих, спортын төрлүүдийг орон нутагт бүсийн хэмжээнд хөгжүүлэх зорилтыг дэвшүүлэн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нутаг дэвсгэртээ нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх
- Иргэд, хүүхэд залуучуудын бие бялдар, чийрэгжилтийг дээшлүүлэх
- Аймгийн болон бүсийн тэмцээнд оролцох баг тамирчдыг бэлтгэх

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт

- Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Манхан спорт цогцолборын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 онд тус байгууллагад дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй бөгөөд сумын төрийн сангаас өдөр тутмын гүйлгээнд хяналт хэрэгжүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 оны шилэн дансанд хийсэн дотоод аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 122267.3 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 1222.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 163763.6 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 1637.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Манхан спорт цогцолборын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 22489.2 мянган төгрөгөөр буюу 1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт	
Авлага	557.56	527.80	-29.76	-5%
Бараа материал	14,195.80	12,455.70	-1,740.10	-12%
Үндсэн хөрөнгө	2,371,312.05	2,350,592.71	-20,719.34	-1%
<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,386,065.41</b>	<b>2,363,576.21</b>	<b>-22,489.20</b>	<b>-1%</b>
Богино хугацаат өр төлбөр	<b>531.25</b>	<b>677.39</b>	146.14	<b>28%</b>
Цэвэр хөрөнгө, өмч	2,385,534.16	2,362,898.82	-22,635.34	-1%
<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,386,065.41</b>	<b>2,363,576.21</b>	<b>-22,489.20</b>	<b>-1%</b>

Авлага дансны үлдэгдэл 527.8 мянган төгрөг болж 29.76 мянган төгрөгөөр буурсан нь 2019 онд үүссэн 557.56 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бүрэн барагдуулан ажиллаж тайлант онд үндсэн данснаас өөрийн орлогын 527.8 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 12455.7 мянган төгрөг болж 1740.1 мянган төгрөгөөр буурсан нь тайланд онд өмнөх оны үлдэгдлээс үйл ажиллагаандаа зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 2371312.05 мянган төгрөг, оны эцэст 2350592.71 мянган төгрөгөөр болж 20719.34 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн данс нь Хөшөөт хөгжил сангийн хөрөнгө оруулалтаар 27724.55 мянган төгрөгөөр гадна тохижилтын ажил хийгдэж нэмэгдсэн байна. Тайлант оны элэгдлийн зардал 48443.88 мянган төгрөг байгаатай холбоотойгоор буурсан байна.

Өр төлбөр оны эхэнд 531.25 мянган төгрөг болж 146.14 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь нийгмийн даатгалын шимтгэлийн өр тайлант онд 146.14 мянган төгрөгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2362898.82 мянган төгрөг болж тайлант онд 22635.34 мянган төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

Манхан спорт цогцолборын 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 41496.2 мянган төгрөгөөр буюу 34 хувиар хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 417784.5 мянган төгрөгийн орлогоос 23437.8 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт, 18083.4 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 23112.5 мянган төгрөгөөр буюу 17 хувиар өссөн, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал 5766.2 мянган төгрөг буюу 8.8 хувиар, тогтмол зардал 23931.1 мянган төгрөг буюу 38.1 хувиар, бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр 232.1 мянган төгрөг буюу 72, урсгал шилжүүлэг 527.8 мянган төгрөг буюу 100 хувиар өссөн, хангамж бараа материалын зардал 1444.9 мянган төгрөг буюу 33.3 хувиар, нормативд зардал 380.0 мянган төгрөгөөр буюу 316.6 хувиар буурсан байна. Энэ нь Засгийн газрын 472 тоот тогтоолоор цалингийн сүлжээ, хэмжээ өөрчлөгдсөн, Ковид-19 цар тахалтай холбоотойгоор үйл ажиллагаа явагдаагүйтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт:**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 136039.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 136039.0 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Сумын ИТХ-ын 2020 оны 09 дүгээр сарын 13/02 тоот тогтоолоор Манхан спорт цогцолборын 2020 оны төсвийг 136039.0 мянган төгрөгөөр баталжээ.

### Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 136039.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 131039.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 5000.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 131039.0 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоор 5000.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж нийт 136039.0 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 135511.2 мянган төгрөгийг зарцуулж 527.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 135511.2 мянган төгрөг буюу 99,6 хувьтай байгаа нь хангамж бараа материалын зардлыг 1084,2 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 322,0 төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээ 527.8 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэсэн шалтгаан нь 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой томилолтын зардал, хог хаягдал орчны бохирдлын арга хэмжээний зарцуулах эрхийг нээж өгөөгүйтэй холбоотой хэмнэлт гарсан байна.

Хүснэгт 3	Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт	/мян.төг/
код	хөтөлбөр, арга хэмжээ	мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	523.8
80109	Тогтмол зардал	4.0
	<b>ДҮН</b>	<b>527.8</b>

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс хугацаандаа оруулсан 139, хугацаа хоцроож 4, огт мэдээлээгүй 7 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого, зарлагын мэдээлэлд 5 сарын 40390.0 мянган төгрөгийн 5 мэдээллийг байршуулаагүй, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгааны тайлбарыг 4-р улиралд мэдээлээгүй, аудитын тайлан зөвлөмжийн мөрөөр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг огт мэдээлээгүй байна.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 1 зөвлөмж өгөгдөж зөвлөмжийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	0	0	0	0	0	0	0
Албан шаардлага	0	0	0	0	0	0	0
Зөвлөмж	1	0	1	0	1	0	100
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>100</b>

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт илэрсэн алдаа зөрчилд алдааг давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

**Залруулсан алдаа:** Аудитаар залруулсан алдаа байхгүй болно.

**Аудитын зөвлөмж:** Аудитаар илэрсэн зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар анхаарал татах асуудал байхгүй байна.

## 4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

### 1. Анхан шатны баримт бүрдүүлэлттэй холбоотой асуудал

1.1 **Илрүүлэлт:** Тайлант онд худалдан авсан бараа бүтээгдэхүүн, захилгаар хийгдсэн судалгааны ажлуудад гарсан зардлуудыг баримтжуулахдаа И баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байна.

1.2 **Эрсдэл:** Төсвийн зарцуулалтын хяналт сулрах, харилцагч байгууллага татвараас зайлсхийх

1.3 **Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.7. “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Татварын ерөнхий хуулийн 28.5. “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалтуудыг мөрдөн ажиллаж, худалдан авалтын ажил гүйлгээ бүрийг И баримтаар баталгаажуулах.

1.4 **Байгууллагаас өгсөн хариу тайлбар:** Хүлээн зөвшөөрсөн

### 2 Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудал

2.1 **Илрүүлэлт:** Тайлант хугацаанд оруулбал зохих 148 мэдээллээс хугацаандаа оруулсан 139, хугацаа хоцроож 4, огт мэдээлээгүй 7 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого, зарлагын мэдээлэлд 5 сарын 40390.0 мянган төгрөгийн 5 мэдээллийг байршуулаагүй, төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн шалтгааны тайлбарыг 4-р улиралд мэдээлээгүй, аудитын тайлан зөвлөмжийн мөрөөр хийж хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг огт мэдээлээгүй байна.

2.2 **Эрсдэл:** Хуулийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байх, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй байх

2.3 **Өгсөн зөвлөмж:** Шилэн дансны тухай хуулийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” гэсэн заалтыг мөрдөн ажиллаж мэдээллийг цаг хугацаанд бүрэн, үнэн зөв мэдээлэх

2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ**

Огноо:	Аудитын нэр:	<i>Манхан спорт цогцолборын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</i>	Аудитын код:
2021			ХОА-2021/129/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Манхан спорт цогцолбор		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	2.1 Тайлант онд худалдан авсан бараа бүтээгдэхүүн, захилгаар хийгдсэн судалгааны ажлуудад гарсан зардлуудыг баримтжуулахдаа И баримтаар баталгаажуулаагүй байгаа нь борлуулагч талыг татвараас зайлсхийх боломжийг бий болгож байна.	0	Зөвлөмж өгөх	Дарга Нягтлан бодогч	А.Дашням М.Бямбацэцэг
2	Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй	0	Зөвлөмж өгөх		
<b>ДҮН</b>					

**ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**